

АРДЫН ЗУРААЧ Г.ОДОН БАГШИЙН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ӨВ

Ц.Ядамжав, МУ-ын гавьяат багш

Abstract: People's Artist of Mongolia Gelegiin Odon is the first artist-teacher, who worked in the Universities as a teacher of painting and a Head of the Department for over 30 years and has successfully participated in the preparation process of hundreds of artists with higher education degree.

As one of the three senior teachers established the Department of Fine Arts and as the first head of the department, he had properly organized the structure and activities of the Department from the initial stage up to the present, so the works of the department have been kept normal for almost half a century.

By the initiative of Professor G.Odon, the class to prepare artists with higher education degree was opened in the country and it has prepared more than 140 artists and craftsmen of 7 graduation. They became the main market of the composition of the artists of the city and 18 artists became the honored masters of the art in Mongolia.

When Professor Odon was working as a head of the department, about 1,500 graduates specialized in a major of fine arts teacher work in schools and universities of Mongolia. The department is a center of art education, and 9 of them have been rewarded by the title of Distinguished Teachers of Mongolia. All these arguments are the valuable cultural heritage that has been significantly contributed by People's Artist and Professor G.Odon to the development of art education.

Түлхүүр үг: дүрслэх урлаг, сурган хүмүүжүүлэх өв, уран зураг, Одон багш

МУБИС-ийн дүрслэх урлагийн тэнхимийг үүсгэн байгуулагчдын нэг МУ-ын ардын зураач төрийн шагналт, ахмад багш Гэлэгийн Одонгийн мэндэлсний 90 жилийн ой энэ онд тохиож байна.

Г.Одон 1925 онд Дорнод аймгийн Баяндун суманд буриад малчны гэрт төрж, 10-аад нас хүртэл ажилч хичээнгүй эцэг, эхийн сургаал халамжид өссөн, унаган багаасаа авьяас билиг нь тодорчээ.

Энэ тухай “Би багадаа хонь малд явахдаа шороо, цасан дээр элдэв юмс мал амьтан зурдаг, модны тахир мурий мөчир салаагаар хүн амьтны дүрс дуурайлган зорох дуртай байсан” гэж дурсан ярьдаг сан.

10 настайдаа сийлсэн монгол бухын сийлбэрээ төрөлх суманд нь байгуулагдсан өөрийн уран бүтээлийн музейд бэлэглэсэн нь одоо ч хадгалагдаж байна.

Монгол орон даяар 1937 онд нэрвэсэн улс төрийн хэлмэгдлийн хар шуурга Одон багшийн амьдралыг дайрч гэмгүй жирийн малчин эцэг Гэлэг нь зөвхөн буриад угсаатан байсны хувьд эсэргүү гэгдэн баривчлан хороожээ. Буриад айл өрөхөд насанд хүрсэн эр хүн бараг үлдээгүй тэр цагт 12 настай балчир хүү Одонд айл өрхийг толгойлох хүнд ачаа оногдсон гэдэг. Гэвч төрөлхийн чардгар (өөрийн нь хэлдгээр) тэрээр хайрт ээжийнхээ сургаал заавар дор өсөн өндийж, сургууль номын мөр хөөж Хөдөө Аж Ахуйн техникумийг 17 насандаа дүүргэж, усны хайгуулын техникч мэргэжил эзэмшин улс орондоо хүчээ үнэлэх ажил хөдөлмөрийн замд оржээ.

Гидротехникчийн ажил мэргэжил зураг зүйтэй нягт холбоотойн дээр төрөлхийн авьяас сонирхолтой тул зураг зурах ажлаа тасралтгүй хийж, муугүй зурдаг байж. Тэр цагийн үеийн уламжлал ёсоор 1945 оны улсын баяр наадмаар Мал Аж Ахуйн Яамны үзэсгэлэнг хариуцан ажиллаж үзэсгэлэнгээ зочдод тайлбарлаж байтал маршал Х.Чойбалсан Энэ зургуудыг хэн зурсан бэ? гэж асуухад Одон Би зурсан хэмээн хэлжээ. Маршал цаашид зураач болох хүсэлтэй эсэхийг түүнээс сонирхсон байна.

Ийнхүү түүний зураач болох замнал эхэлсэн түүхтэй.

Түүнээс хойш тэр үеийн Соёлтой багшийн удирдан явуулдаг зургийн дугуйланд хэсэг нөхдийн хамт суралцаж мэргэжлийн зураачийн дөртэй болжээ. Тэр хооронд өөрийн зураг зурах ажилд хичээнгүйлэн цөөнгүй бүтээл туурирсан нь урчуудын байгууллагын удирдлагуудын анхааралд өртөж, мэргэжлийн сургуульд суралцах хэрэгтэйг түүнд зөвлөсөн байна.

1946 онд сургуульд явах хүсэлтээ Х.Чойбалсанд мэдүүлснээр ЗХУ-ын Москва хот дахь В.И.Суриковийн нэрэмжит уран зургийн академид суралцах зөвшөөрөл олгов.

1951 онд Уран Зургийн Академийг дүүргэсэн анхны монгол зураачдын нэг болсон бөгөөд Академи төгсөж ирсний дараа зураг урлалын

газарт, зураач, дүрслэх урлагийн дунд сургуульд багш зэрэг ажил эрхлэхийн хамт уран бүтээлийн ажилдаа шаргуу оржээ. Г.Одон багш дээд боловсролтой зураачийн хувьд уран зураачдаас өндөр уран чадвар шаарддаг том хэмжээний сэдэвт уран зураг болох <<Сангийн аж ахуйд >>, <<Толбо нуурын бүслэлт >>, <<Уран сайханчид >>, зэрэг бүтээлүүд, түүний дотор <<Ажлын дараа >> нэртэй монгол малчин ардын аж байдал, ажил хөдөлмөрийн онцлогийг харуулсан уран зураг туурвисан нь монголын уран зургийн сан хөмрөгт, өндөр үнэлгээ бүхий шилдэг бүтээлд зүй ёсоор тооцогдож байна.

Г.Одон гуайн бүтээлч үйл ажиллагааны 30 гаруй жил нь багшлах болсон хүчин бэлтгэх ажилтай холбоотой байна. Тэрээр өөрийн сурган хүмүүжүүлэх өвийг үлдээсэн юм. Нэрт зураач бүрт оногдоод байдаггүй түүний сурган хүмүүжүүлэх өвийг дараах гурван зүйлээр тодорхойлж болно.

1. 1958 онд УБДС-д зураг хөдөлмөрийн багшийн анги нээгдсэнээр Монгол улсад үндэсний дээд боловсролтой дүрслэх урлагийн багш, зураач бэлтгэж эхэлсэн юм. Шинэ тутам болохоор саад бэрхшээл бишгүй л тохиолдож байсны дотор мэргэжлийн багшийн асуудал хамгийн хүндрэлтэй, дүрслэх урлагийн багшийн ажлыг шууд эрхлэх хэмжээнд бэлтгэгдсэн зураач ховор байсан тул эхлээд ЗХУ-д уран зургийн академи төгссөн зураач Л.Гавааг уран зургийн багш, Ц.Доржпаламыг хар зургийн цагийн багшаар ажиллуулжээ. Энэ хоёр зураач Ардын дуу бүжгийн чуулга, хөгжимт драмын театрын ерөнхий зураачаар ажиллаж байсан тул цаг зав муутай, дээд сургуульд олон өдөр хичээл заах боломж хомс учир шинээр үндсэн багш авах хэрэгтэй болжээ. Шаварт унасан шарын эзэн хүчтэй гэдэгчлэн тэнхимийг үүсгэн байгуулагч Б.Гончигдорж багш нэг талаар нийгмийн чухал ажлын шаардлага гэдгийг өмнөө барьж, нөгөө талаар танил сайн нөхрийн журмаар МУЭ-ийн дарга Н.Чүлтэмийн хөлд сууж байгаад МУ-ын урлагийн гавъяат зүтгэлтэн Г.Одонг 1959 онд УБДС-д багшлуулахаар шилжүүлэн авч ирсэн гэдэг. 1960 онд Дүрслэх урлагийн тэнхим байгуулж анхны тэнхимийн эрхлэгчээр Одон багшийг томилсон юм. Одон багшийн санаачлага зүтгэлийн үр дүнд 1963 онд УБДС-д уран зураачдыг бэлтгэх анги нээж 6 удаагийн төгсөлтөөр 140-өөд уран зураачдыг бэлтгэн байна. Эдгээр зураачид манай улсад сонгодог дүрслэх урлагийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гэдгийг Одон багшийн шавь нараас 18 хүн МУ-ын урлагийн гавъяат зүтгэлтэн, гавъяат багш

цолоор шагнагдсанаас бэлхэнээ харж болно.

2. Шинэ тутам байгуулагдаж байсан зургийн сургууль, тэнхимд багшлах ажлын туршлагатай зураач-багш гэж байгаагүй тул шинээр бэлтгэх зорилт тулгарчээ. Ийм нөхцөлд багшлах ажилд дур сонирхолтой зураач урчуудыг Одон багш урьж ажиллуулсан юм. 1959 онд Ленинградын И.Е.Репины нэрэмжит урлагийн академи төгссөн зураач А.Даваацэрэн, БНХАУ-д мэргэжил эзэмшсэн нэрт сийлбэрч А.Гэвшээхүү, 1960 онд БНХАУ-д суралцсан зураач Б.Балдан, 1961 онд ЗХУ боловсрол эзэмшсэн Б.Чогсом, 1963 онд И.Е.Репины нэрэмжит академи төгссөн С.Нацагдорж, 1973 онд мөн академи төгссөн зураач Г.Баяраа нарын өндөр боловсрол, ур чадвартай зураач урчуудыг сургуульдаа татан ажиллуулжээ. Мөн 1959 онд ЗХУ-аас В.Суриковийн нэрэмжит уран зургийн академид өөртэй нь хамт сурч байсан Москвагийн багшийн дээд сургуулийн уран зургийн багш А.П.Страгонов, 1961 онд нэхмэлийн дээд сургуулийн багш Ж.Ш.Дшамайл нарыг урьж багшлуулсан байна. Эдгээр академик боловсролтой уран зураачид багшаар ажиллаж байсан явдал нь манай МУБИС-д ур чадвартай багш нарыг бэлтгэхэд үлэмжхэн хувь нэмэр болсон бөгөөд Одон багшийн өөрийнх нь захиж хэлснээр урлагийн эсэн бусын урсгал чиглэлд авталгүй сонгодог арга барилаар сургалтаа явуулж байх чиг хандлагыг тогтоож өгсөн юм. Багш бэлтгэх ажлын дараагийн шатанд Г.Одон багшийн санаачлагаар өөрийн шавь нараас багшаар ажиллуулах зорилт тавьж зураг-хөдөлмөрийн анхны төгсөлтөөс А.Ф.Сирагонов багшийг дагалдан суралцсан Ц.Ядамжавыг дүрслэх урлагийн багшаар, Ц.Цэрэнжавыг технологийн багшаар үлдээж ажиллуулав. Үүний дараа 1964 онд С.Жамц, 1965 онд Л.Батмөнх нарыг, хожим нь 1974 онд Ж.Төмөрбат, 1976 онд С.Батчулуун, 1984 онд Д.Дашхүү нарыг багшаар бэлтгэн ажиллуулсан нь өөрийн сургуулиар багш бэлтгэх бололцоотойг харуулсан төдийгүй тэд ч туршлагатай, сайн уран бүтээлч багш болон төлөвшсөн нь Одон багшийн хичээл зүтгэл хэмээн үзэж болохоор байна.

Гурав: зураач бүр өөр өөрийн онцлог арга барилтай, түүгээр уран бүтээлийг нь таньдаг үнэлдэг, шавь нар нь тэр арга барилыг уламжлуулан авч хөгжүүлдэг жамтай билээ.

Г.Одон багш Оросын уран зургийн реалист аргыг чадварлаг эзэмшсэнээс гадна олонд үнэлэгдсэн сайхан уран бүтээлүүд туурвисан нэр

алдартай зураач байсан бөгөөд шавь нартаа зааж сургах өвөрмөц аргатай байсан юм. Тэр арга нь Одон багш оюутанд зуруулах зүйлээ (натюрморт, натур) эхлээд тал бүрээс нь сайтар тайлбарлаж ойлгуулаад, өөрөө оюутны зурах хэмжээний цаас, холстоо бэлтгэж, хамгийн тохиромжтой байрлалыг сонгоод уран зураг бүтээх шат дарааллыг яс баримталж аажуухан зурж эхэлнэ. Үе үе мольвертийн араас босож оюутнуудын ажлыг нэг бүрчлэн үзэж сайн ба дутагдалтай талыг сайтар тайлбарлаж өгнө. Харин оюутны ажилд гар хүрч засахыг чухалчлахгүй. Нэгэнт үлгэр жишээ авахаар багшийн ажил өмнө нь байгаа, дээр нь сайн зөвлөгөө авсан болохоор оюутны ажил амжилттай, муухан ярианаас илүү өгөөжтэй болдог байв.

Энэ бол ардын зураач Г.Одон багшийн дүрслэх урлагийн сургалтад оруулсан дагуулан сургах өвөрмөц арга мөн. Өөр олон зураачид багшийн ажил эрхэлдэг боловч тэр бүхэн Одон багш шиг өөрийгөө дагуулан сургах нь ховор байдаг.

Бас дээр нь хүн бүрийн хувийн онцлог, эрх чөлөөнд халдаж болохгүй гэх “сургаалд” дулдуйдан оюутантай ойртон ажиллах багш ховордсон өнөө үед Одон багшийн арга зайлшгүй хэрэгтэй байна даа.

Уран бүтээл дээрээ ажиллаж дууссаны дараа бийр болон нийлүүрээ (палитар) маш сайн цэвэрлэж угаагаад дараагийн ажилдаа бэлэн байлгадаг нь шавь нарт сайхан үлгэр жишээ болдогийг нэрт зураачид болсон Н.Орсоо, Ө.Сүхээ, Дунбүрээ нар одоо ч дурсаж байдаг. Одон багш шинэ уран бүтээлийн сэдэв сонгосон бол эхлээд заавал анхны ноорог (эскиз) зургаа гаргаж, дүр тус бүр дээр натураас судалгаа хийснээ үндэслэж эх зургаа туурвина. Энэ бол орчин үед бэлэн гэрэл зураг хараад зурчихдаг тэр нь жинхэнэ уран бүтээл биш, зөвхөн хуулбар төдий болдог, зарим хэлбэр хөөцөлдсөн залуу залуу зураачдад сургамж сануулга болох том сургууль юм шүү. Г.Одон багш өөрөө урлагийн элдэв урсгал чиглэлээс хол байж зохируул авцалдаагүй өнгө, бодит дүрслэлгүй, хийсвэр, хэлбэржсэн урлагт хэт автахгүй байхыг шавь нартаа байнга сургамжилж байв.

Г.Одон бол алдар нэртэй том зураач боловч цаг үргэлжид шинэ ажил, санаа сэдэж залуу багш нарыг хотын ойр орчмоор дагуулан явж этюд судалбар хийдэг, долоо хоногт нэг өдрийг уран бүтээлийн өдөр болгож хамтдаа натур зурдаг байсан нь багш нарын мэргэжил чадварыг дээшлүүлэхэд үлэмж ач холбогдолтой байв. Дүрслэх урлагийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах чиглэлээр “Үнэн”, “Утга

зохиол урлаг” сонин, “Дүрслэх урлаг”, “Соёлын ажилтанд тусламж”, “Социалист хөдөө аж ахуй”, “Соёл урлаг” зэрэг сэтгүүлүүдэд 30 гаруй өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлсэн байна. Мөн дүрслэх урлагийн сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгоход идэвх санаачлага гаргаж дээд, дунд сургуулийн сурах бичиг, сургалтын материал боловсруулан хэвлүүлэхэд зохиолч, редактораар удаа дараа ажилласан юм. Дүрслэх урлагийн тэнхимээс бэлтгэн 1988 онд хэвлүүлсэн “Хар зураг” хэмээн дээд сургуулийн сурах бичигт хамтран зохиогч, редактораар Г.Одон багш ажилласан нь тус бүтээлийг сайжруулахад чухал нөлөө үзүүдсэн юм. Энэ бүгд МУ-н ардын зураач, төрийн шагналт Г.Одонгийн дүрслэх урлагийн сургалтад оруулсан онцлог, хувь нэмэр, цаашид хадгалагдах үнэт өв болон үлдэж байна.

ДҮГНЭЛТ

Ардын зураач Гэлэгийн Одон МУБИС, СУИС зэрэг их сургуулиудад 20 гаруй жил уран зургийн багшаар ажиллаж, Монголд уран зургийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх ажилд биечлэн оролцсон анхны зураач юм.

- МУБИС-ийн дүрслэх урлагийн тэнхимийг анх үүсгэн байгуулахаас эхлэн багш, тэнхимийн эрхлэгч, зөвлөх багшаар ажиллахдаа их, дээд сургуульд багшийн ажил эрхлэх боловсрол, чадвартай 20 гаруй профессор багш нарыг биечлэн бэлтгэн төлөвшүүлсэн нь Урлаг, Биеийн тамирын сургуулийн мэргэжлийн үндсэн багш нар болсон түүхтэй.
- Монгол улсад үндэсний дээд боловсролтой уран зураач, бэлтгэх ажлыг анх санаачлан зохион байгуулж долоон удаагийн төгсөлтөөр 140 гаруй зураач, урчуудыг бэлтгэсэн нь урчуудын байгууллагын боловсон хүчний гол цөм болж тэдний дундаас төрийн шагналт, урлагийн гавьяат зүтгэлтэн 18 зураач төрөн гарсан байна.
- Г.Одон багш тэнхимийн эрхлэгчээр ажиллах хугацаандаа дүрслэх урлагийн багш бэлтгэх ажлыг гардан зохион байгуулж, 1500 гаруй багш бэлтгэсэн нь ард нийтийн уран сайхны боловсрол, гоо зүй, ёс суртахууны хүмүүжлийг төлөвшүүлэхэд голлох цөм болж байгаа юм. Тэдгээрийн дотроос есөн багш МУ-н гавьяат багш цолоор шагнагдсан байна.
- Г.Одон багш МУБИС-ийн дүрслэх урлагийн тэнхимийг байгуулах, цаашид

удаан жил бат тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж их, дээд сургууль, ЕБДС-н мэргэжлийн олон мянган багш, уран зураачдыг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нь үеийн үед дурсагдах гавьяатан мөн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Нандин-Эрдэнэ, Б. (2008). *Ардын зураач Б. Чогсом*. Улаанбаатар.
- Лувсанвандан, С. (1982). *Монголын урлагийн уламжлал шинэчлэл*. Улаанбаатар
- Отгонтөгс, Д. (2012). Монголын орчин үеийн дүрслэх урлагийн түүх (1911-2011). Улаанбаатар
- Чүлтэм, Н. (1988). Монголын уран зургийн хөгжлийн товч түүх. Улаанбаатар
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2013). *Дүрслэх урлаг технологийн сургууль-55 эмхэтгэл*, х.68
- Бавуужав, Н. (2015). *Өнө мөнхөд дурсагдах хүн*. Улаанбаатар